

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил,.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1.	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
2.8.2.	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3	Менежментийн захидал	13
3.1.	Хучилтын орлогын бүртгэл ба түүний хяналттай холбоотой асуудал	13
3.2.	Харилцах дансанд мөнгөн хөрөнгийн менежмент хийхтэй холбоотой асуудал	14
3.3.	НӨАТ-ыг бүртгэж байгаатай холбоотой асуудал.....	16
3.4.	Нөхөн сэргээлтийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал.....	16
3.5.	Тендерийн шаардлага хангахгүй утгуурт ачигч худалдан авсантай холбоотой асуудал.....	17
3.6.	Зүүн цанхийн олборлогч “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-тай холбоотой асуудал.....	18
3.7.	Төсөв ба түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудал	20
3.8.	Компанийн засаглалтай холбоотой асуудал.....	21
3.9.	Авто зам, төмөр замд хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал	22
3.10.	Нүүрсний үлдэгдэлд хяналтын тооллого хийсэнтэй холбоотой асуудал.....	23

3.11. Лицензээрх биет бус хөрөнгө болон түүний элэгдүүлэлттэй холбоотой асуудал..	24
3.12. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал	25
3.13. Мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой асуудал	26
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	27
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	27
4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	29
4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	30
4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ЭТТ	Эрдэнэс Таван толгой ХК
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник Эдийн Засгийн Үндэслэл
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
УОО	Урьдчилж орсон орлого
НББ	Нягтлан бодох бүртгэл
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.28 № 06/617
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Олборлогч компанитай тооцоо нийлж чадахгүй байгаа талаар

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн Зүүн цанхийн уурхайн олборлогч “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хоорондын тооцооны үлдэгдлээ нийлж чадаагүй байна. Олборлогч компани үнийн өөрчлөлтийн өсөлт бууралтын тохируулга 9.1 сая ам.доллар буюу хаалтын ханшаар 24.1 тэрбум төгрөгийг нэхэмжилж байгаа боловч “Эрдэнэс Таван толгой” ХК нь өгөх боломжгүй гэж үзэж байгаа.


Үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь өглөгийн үлдэгдлийг нотлох боломжгүй болсон ба энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл болон санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “оршин байх” болон “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс Таван толгой” ХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Конфиденсе Аудит” ХХК-ийн П.Ариунаа ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Санхүүгийн аудитын газар-т 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 01/389 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Эрдэнэс Таван толгой” ХК нь Тавантолгой ордын хайгуул, судалгаа болон олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлж, сайн чанарын нүүрсний үндэсний брэнд бүтээгдэхүүн бий болгож олон улсад гаргах, аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхай, аж үйлдвэрийг хөгжүүлэн улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмрээ оруулж, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн үр өгөөжийг хүртээх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хувьцаат компанийн дүрмээр "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нүүрсний ордын хайгуул, судалгаа, олборлолт, борлуулалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа
- Ложистикийн үйл ажиллагаа, гаалийн хяналтын бүсэд бүтээгдэхүүн хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх
- Ордыг ашиглахтай холбоотой боловсруулах үйлдвэр байгуулах, шаардлагатай дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор лабораторийн үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 245 дугаар тогтоолоор “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг томилсон. Үүнтэй холбоотойгоор “Эрдэнэс Таван толгой” ХК байгуулах тухай” Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 272 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн охин компани хэлбэрээр” гэсэн хэсэг, “Журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.6 дахь хэсгийн “Эрдэнэс Таван толгой” ХК” гэсэн хэсгийг тус тус хассан.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн удирдлага дараах хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Би Ти солюшн ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Силикон 2.0 болон Силикон 3.0 санхүүгийн програм хангамж ашигладаг байна.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 21 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Төсөвлөсөн борлуулалтын орлого*-ын 2 хувиар сонгов.

Төсөвлөсөн борлуулалтын орлого-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь

- Компани 2017 онд төрийн болон ард түмний хувьцааг санхүүгийн тайландаа бүртгэсэн.
- Дээрх бүртгэлээс шалтгаалан балансын дүн 11,182,447.9 сая төгрөгөөр нэмэгдсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 224, 245 дугаар тогтоолын дагуу IPO хийж хөрөнгө оруулалт татахаар төлөвлөсөн.
- 2017 оноос компани ашигтай ажиллаж эхэлсэн.
- Гадны хөрөнгө оруулагчдыг татаж, зарим төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой юм.

"Эрдэнэс Таван толгой" ХК-ийн 2018 оны *Төсөвлөсөн борлуулалтын орлого* 1,258,814.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 25,176.3 сая төгрөгөөр төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг хэвээр үлдээв.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 27 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 15 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон бодит ханшийн олзыг бодит бус ханшийн олзод шилжүүлэх залруулга
- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тооцсон бодит ханшийн гарзыг бодит бус ханшийн гарзад шилжүүлэх залруулга
- Авлага өглөг дансны хэрэгжсэн ханшийн зөрүүгийн олзыг тооцсон залруулга
- Авлага өглөг дансны хэрэгжсэн ханшийн зөрүүгийн гарзыг тооцсон залруулга

- 2018 оны 12 дугаар сарын 31-ны хаалтын ханшийг нөхөж тооцоолсон залруулга
- Хойшлогдсон татварын хөрөнгийг илүү тооцоолсон байсныг шилжүүлэх залруулга
- Орлогын албан татвар бууруулсан залруулга болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2. Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	14	2,998.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	-	-	
3	Албан шаардлага өгсөн	1	-	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	-	-	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	-	-	
	Дүн	15	2,998.6	

2.8.3. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулсан бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал дараах байдалтай байна. Үүнд:

Хөрс хуулалтын хөрөнгийн бүртгэлийн талаар

ТЭЗҮ-д хөрс хуулалт болон нүүрс олборлолтын харьцааг үе шат болгонд гаргаж өгсөн. Энэ харьцаагаар хөрс хуулалтын хөрөнгийг зардалд системтэйгээр шингээхийн тулд илүү хуулсан хөрс хуулалтыг хойшлуулж биет хөрөнгөөр бүртгэдэг. “Эрдэнэс Таван толгой” ХК нь ТЭЗҮ-д заасан харьцаанаас илүү дүнгээр элэгдүүлсэн байна. Энэ нь 2018

оны борлуулсан бүтээгдэхүүний өртөг, бараа материалын үлдэгдэлд материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 5.1.6-д “зохицох” гэж заасныг тус тус зөрчсөн байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх талаар удирдлагад албан шаардлага хүргүүлсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 154-р тогтоолын 8.2-т заасны дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайланд биет бус хөрөнгө болон хувьцааг 11,196,000.0 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрсөн. 2019 онд хийгдэх бизнес үнэлгээ, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын компаниар хийгдэх аудит, ТЭЗҮ зэрэгт биет бус хөрөнгийг хэрхэн тусгагдсаныг анхаарах
- Төсөв ба гүйцэтгэлийн зөрүүг хэтрэлт ба хэмнэлтээр гаргаж Төлөөлөн Удирдах Зөвлөлд өгч үр дүнгээ үнэлүүлээгүй байсан. Цаашид төсөв гүйцэтгэлийг харьцуулж төсвийн хэтрэлт хэмнэлтээ ТҮЗ-д үнэн зөв тайлагнаж байгаа эсэхийг анхаарах

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 27 дугаар тогтоолоор “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны борлуулалтын орлогын таамаглал 1,258,814.5 сая төгрөг, үйл ажиллагааны зардлын төсөв 958,252.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсөв 618,198.3 сая төгрөгөөр батлагджээ.

Компани 2018 онд уулын ажлын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн, нүүрсний үнэ өссөн, төгрөгийн ханш суларсан зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан борлуулалтын орлого төлөвлөгөөнөөсөө давж 1,986,874 сая төгрөгт хүрсэн. Гүйцэтгэлийг төсөвтэй харьцуулж үзэхэд борлуулалтын орлогыг 57 хувиар, нийт ашгийг 139 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс Таван толгой” ХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Эрдэнэс Таван толгой” ХК Шилэн дансны нэгдсэн систем болон байгууллагын цахим хуудсанд байршуулах 7 төрлийн 62 мэдээллийг бүрэн байршуулсан байна. Тайлант онд цахим санд жилд нэг удаа оруулах 2 мэдээллээс нэгийг нь хугацаа хоцроож оруулсан. Сар бүр оруулах 60 мэдээллээс 43-ыг нь хугацаа хоцроож оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 84 хувьтай байна. Дараах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Үүнд:

- Лицензээрх биет бус хөрөнгийг шинээр хийгдэх ТЭЗҮ, бизнес үнэлгээ, биет бус хөрөнгийн үнэлгээнд суурилан дахин тооцоолж залруулахыг зөвлөмжөөр өгсөн. 2018 онд төлөвлөгдөж байсан зөвлөх үйлчилгээний ажлуудын тендерийн үйл ажиллагаанууд цуцлагдаж зөвлөх үйлчилгээгээ авч чадаагүй ба 2019 оны төсөвт эдгээр зөвлөх үйлчилгээний ажлыг дахин тусгаж батлуулсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Олборлогч компанитай тооцоо нийлж чадахгүй байгаа асуудлыг эс тооцвол “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэс Таван толгой” ХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Хучилтын орлогын бүртгэл ба түүний хяналттай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

2018 онд нийт 170 тээврийн компани нүүрс тээврийн ажил хийж гүйцэтгэсэн. Машин нүүрс ачсаны дараа “Эрдэнэс Таван толгой” ХК (Цаашид ЭТТ гэх) -ийн борлуулалтын хэлтсийн ажилчид ачааны машиныг хучиж гаалийн баталгааны лац тавьдаг. Нэг машины хучилт 6,500 төгрөг ба тээврийн компани нэг бүртэй тооцоо нийлж хучилтын авлага болон борлуулалт бүртгэдэг.

Бодит байдлаас шалтгаалан орон нутаг хариуцсан нягтлан бодогч сар бүр 170 орчим тээврийн компанид нэхэмжлэх явуулах, эргэн төлөлтийн талаар болон үлдэгдлийн талаар захидал бичих, утсаар ярих, тооцоо нийлэх хэрэгтэй болж байна. Үндсэн үйл ажиллагааны бүртгэлийн ачааллын зэрэгцээ үндсэн бус үйл ажиллагаанд түүнээс ч их анхаарал хандуулж цаг заваа гаргаж байна.

3.1.2. Эрсдэл:

Үндсэн үйл ажиллагааг бүртгэх болон хяналт тавих цаг хугацааг жижиг асуудалд зарцуулж байна.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Нүүрс хучилтын тооцоог нүүрс худалдан авагч үндсэн компанийн тооцоонд оруулж сард нэг удаа нийт ачилт хийсэн машины тоогоор тооцож байх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Харилцах дансанд мөнгөн хөрөнгийн менежмент хийхтэй холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

- 2018/12/31-нээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 605.2 тэрбум төгрөг байна. Компани мөнгөн хөрөнгийн менежмент хийлгүйгээр зөвхөн харилцах дансны үлдэгдэлд хүү бодуулахад 2018 онд 3.8 тэрбум төгрөг болсон.

Тодорхой хувийг нь хадгаламжид хийсэн бол ямар боломж байсныг тооцоолж үзвэл дараах байдалтай байна.

Утга	2017.12.31 төгрөг	2018.12.31 төгрөг	Жилийн дундаж
Мөнгөн хөрөнгө	86,000,000,000	605,000,000,000	347,000,000,000
Чөлөөт мөнгөн хөрөнгийг 50% гэж тооцвол	43,000,000,000	304,000,000,000	173,500,000,000
2018 оны хаалтын ханшаар/ам.доллар/	2,642.92		\$ 65,647,087
3 сарын хугацаатай ам.долларын хадгаламжийн хүү	2.4%		\$ 1,575,530
2018 оны хаалтын ханшаар /төгрөг/	2,642.92		4,164,000,000
2018 оны дундаж үлдэгдэл авсан банкны хүү		3,881,582,610	
Хадгаламжаас үлдсэн мөнгөнд үлдэгдлийн хүү авах боломж 50%			1,940,791,305
Тооцоолсон буюу авч болох хүү			6,104,791,305
2018 онд олсон хүү			3,881,582,610
Алдсан боломж			2,223,208,695

2. Нийт 9 банкинд 28 харилцах данстай ба үүнээс 10 харилцах дансанд тайлант жилийн туршид хөдөлгөөн гараагүй. Үүнээс 2 харилцах дансанд 1.2 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний юань хөдлөөгүй байна. Голомт банк, Улаанбаатар хотын банк нь эдгээр харилцах дансад хүү төлөөгүй байна. Дараах тооцоолсон дүнгээр байгууллагыг хохироосон байна.

Банкны нэр	2018.12.31		
	Юань	Хаалтын ханш	Төгрөг
Голомт банк	¥ 829,854	385.73	320,099,583
Улаанбаатар хотын банк	¥ 2,462,689	385.73	949,933,028
Нийт дүн	¥ 3,292,543		1,270,032,611
Банкны үлдэгдэлд боддог хүүгийн жилийн дундаж хувь			5%
Нийт олгох байсан хүү			63,501,631

3.2.2. Эрсдэл:

Мөнгөний менежментийг хийхгүй байснаас нэмэлт орлого олох боломжоо алдаж байна.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн менежмент хийх талаар арга хэмжээ авч ажиллаж холбогдох алба хэлтсүүдэд үүрэг болгох. Үүнд:

- Төсөвлөсөн мөнгөн урсгал гаргаж сар, улирал, хагас ба бүтэн жилээр батлуулах
- Төсөвлөсөн мөнгөн урсгалаас илүү гарсан мөнгөн хөрөнгөнд менежмент хийх
- Мөнгөн хөрөнгийн гүйцэтгэлийн тайланг сар улирлаар гаргаж төсөвтэй харьцуулах

Мөнгөн хөрөнгийн менежмент гэдэгт юуг хамруулан үзэх вэ гэдгийг тодорхойлох. Үүнд:

- Ямар валютаар мөнгийг байршуулах
- Хэдэн төгрөгийг хэд хоногоор тухайн банкинд байршуулах
- Хичнээн хэмжээний хадгаламжийг аль банкинд байршуулж болох
- Мөнгөн хөрөнгийн эрсдэл түүнээс яаж хамгаалах
- Валютын арилжаа хийх боломжтой эсэх
- Засгийн газрын богино хугацаат бонд авах боломжтой эсэх

Эдгээр асуудлуудыг хамруулсан бодлого гаргаж хэрэгжүүлснээр компани бэлэн мөнгийг зөв удирдаж илүү их өгөөж олох боломж харагдаж байна.

- Мөн ашиглагдахгүй байгаа харилцах дансыг хаах эсэх талаар байгууллага шийдвэр гаргах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. НӨАТ-ыг бүртгэж байгаатай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

ЭТТ нь үндсэн борлуулалтаасаа НӨАТ төлдөггүй ба буцаалт авдаггүй. Харин дотоодод борлуулсан нүүрс болон бусад үндсэн бус үйл ажиллагааны орлогоос НӨАТ төлдөг.

Гэвч бүх НӨАТ -ын баримттай худалдан авалтыг бүртгэлд тусгахдаа НӨАТ-ыг салгаж татварын авлага үүсгэдэг. Энэ бичилтээ нэг бүрчлэн буцааж бичдэг ба буцаах бичилтийг үнэн зөв хийж байгаа эсэхийг хянах ямар нэгэн хяналтын горим хэрэгжүүлдэггүй байна. Уг бүртгэл нь компанийн хувьд зайлшгүй шаардлагатай биш харин ч ажилчдын ачааллыг нэмэгдүүлж, журналын бичилтийн тоог эрс ихэсгэж байна.

3.3.2. Эрсдэл:

Бүртгэлд алдаа гарах магадлалыг нэмэгдүүлж байна.

3.3.3. Өгсөн зөвлөмж:

- Компани нэгэнт л ихэнх худалдан авалтынхаа НӨАТ-ыг буцааж авч чаддаггүй тул ингэж салгаж бүртгэх шаардлагагүй гэж үзэж байна. ЭТТ худалдан авалтаараа дамжуулан хичнээн хэмжээний НӨАТ төлснийг НӨАТ-ын цахим бүртгэлээс гарган авах боломжтой юм.

- НӨАТ-ын буцаан авалтыг заавал салгаж бүртгэнэ гэж шийдвэл энэхүү бүртгэлийг програмаар автоматаар хийдэг тохируулга хийлгэх.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Нөхөн сэргээлтийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Нөхөн сэргээлтийн санг 2017 он дуустал борлуулалтын нэг хувиар үүсгэж, ирээдүйн жилүүдэд хуваарилан элэгдүүлж байсан. Үүнийг үнэн гэж үзэх боломжгүй учраас өмнөх аудитын компаниудын дүгнэлтээ хязгаарлах нэг үндэслэл болсон.

2018 онд нөхөн сэргээлтийн тайланг зөвлөх компаниар бэлтгүүлж авсан ба уг тайлангаар 2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болгож уурхайг татан буулгана гэж үзвэл 31,000.0 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн зардал гарна гэж үнэлсэн. Энэ үнэлгээнд суурилан элэгдээгүй байсан нөхөн сэргээлтийн хөрөнгийг бүгдийг нь элэгдүүлж залруулга хийсэн. Харин 2019 он болон түүнээс цааш нөхөн сэргээлтийн хөрөнгийг хэрхэн бүртгэх элэгдүүлэх талаар ЭТТ бодлого журамгүй байгаа болно.

3.4.2. Эрсдэл:

Компани тогтсон нэг бодлого журамтай байж түүнийгээ тасралтгүй, тогтмол хэрэгжүүлдэг байх гэсэн зарчим алдагдана.

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Ирээдүйд шаардагдах нөхөн сэргээлтийн хөрөнгийг үнэлүүлж НББ-дээ тусгах. 2019 онд ЭТТ-ийн ТЭЗҮ ирээдүйн 30 орчим жилээр бичигдэх төлөвлөгөөтэй байгаа үүнд суурилан ирээдүйн нөхөн сэргээлтийн хөрөнгийг тооцоолох боломжтой гэж үзэж байна.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.5. Тендерийн шаардлага хангахгүй утгуурт ачигч худалдан авсантай холбоотой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

ЭТТ нь овоолгод байгаа нүүрсийг машинд ачих ажлаа бусдаар гүйцэтгүүлдэг байснаа өөрчилж зарим ачилтыг өөрсдөө хийдэг болсон. Үүний тулд 2 ширхэг утгуурт ачигч худалдан авах шаардлага бий болж 2017 онд тендер зарлаж эхний тендер хүчингүй болсон байна. 2 дахь тендер зарлахад “Вагнер ази” ХХК болон “Майнс ап” ХХК оролцож материалаа ирүүлсэн байна. Тендерийн хорооны үнэлгээгээр “Майнс ап” ХХК ялж тухайн компаниас худалдан авахаар гэрээ хийгдэж 2,998.6 сая төгрөгөөр 2 ширхэг утгуурт ачигч авсан байна.

Худалдан авалт хийгдэх үед үүссэн байсан асуудал

- “Wheel loader L 580” утгуурт ачигчийн үйлдвэрийн тодорхойлолтоор утгуурын эзэлхүүн 5,2м³-5.7 м³ байна гэж заасан байхад 7.3 м³ –ээс доошгүй байна гэсэн тендерт ялсан.
- “Майнс ап” ХХК нь тендерийн материал дээрээ 9м³ ачаа өргөх чадалтай гэж оруулж ирсэн байна.
- “Майнс ап” ХХК нь үйлдвэрээс ирсэн утгуур дээр нь гагнуур хийж шанага томруулсан байна.

- Утгуурт ачигчийг худалдан авах туршилтын үед уурхайн зарим ахлах ажилчид хүлээн зөвшөөрөхгүй гэж байжээ.

3.5.2. Эрсдэл:

Худалдан авалт хийснээс хойш уг ачигчаар ажил хийх үед дараах асуудлууд гарч байгууллагыг хохироосоор байна.

- Ачигч нь үйлдвэрийн хүчин чадлаасаа том шанагатай ажиллаж байгаагаас шалтгаалан гидрийн хоолой задрах,
- Шанаганы хэмжээг нэмэгдүүлж өөрчилснөөр ажлын бүтээмж буурч нэг машиныг ойролцоогоор 15 минутанд ачдаг болсон ба үүнээс шалтгаалан баруун цанхийн ачилтын хэсгийн ажилчид шагналт цалингаа авч чадахгүйд хүрэх,
- Баруун цанхийн ачилт хийх машины дараалал ихсэх,
- Даацаасаа хэтэрсэн утгууртайгаас 2 ачигчийн урд шил хагарч засвар хийх шаардлагатай болсон ба уг шилнүүд 45 хоногийн дараа бэлэн болох тул баруун цанхийн ачилт саатах,
- Нэмэгдсэн шанаганы эзэлхүүнээрээ бүтэн хутгавал техник унах зэрэг эрсдэлтэй.

3.5.3. Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын гэрээнд 1 жил 6,000 мото/цаг ажиллах баталгаа өгсөн байна. Энэ баталгаат хугацаанаас өмнө 2 ачигчийн талаар ажлын хэсэг гарган “Майнс ап” ХХК-иас шаардлага хангасан ачигч авах эсвэл төлбөрөө буцаан авч байгууллагыг хохиролгүй болгох ажлыг яаралтай эхлүүлэх.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.6. Зүүн цанхийн олборлогч “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-тай холбоотой асуудал

3.6.1. Илрүүлэлт:

ЭТТ-ийн зүүн цанхийн гэрээт олборлогч компаниар “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК 2016 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны гэрээ эхний ээлжинд тогтвортой 33 сар байхаар хийгдсэн ба 2016 оны гэрээгээр 38 сар болж сунгагдсан. Энэ хугацаа нь 2019 оны 2-р сарын 28-наар тасалбар болон дуусаж байгаа. Гэрээний заалтын 5.4-т эхний 38 сар дууссаны дараа гэрээг дүгнэнэ, хэрвээ гэрээний биелэлтийн үнэлгээ 70 хувиас доош буухгүй бол гэрээг шууд 24 сараар сунгана гэж заасан байна.

“Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-тай хамтран ажилласнаар компанид дараах асуудлууд үүссэн байна. Үүнд:

1. 2016 онд хийгдсэн нэмэлт гэрээнд 1м3 уулын ажлыг 2017 оны 1-р сарын 1-нийг хүртэл 3.99 ам.доллар байхаар цаашид 4.36 ам.доллар байхаар заасан байна. 2017, 2018 онуудын уулын ажлын төлбөрийг бууруулж 3.99 ам.доллар болгох саналыг ЭТТ зүгээс “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-ийн удирдлагад тавьсан. Уг тохиролцоог тухайн жилүүдийн эхэнд хийж чадахгүй байсаар жилийн эцсийн санхүүгийн тайлан бэлтгэхээс 1-2 хоногийн өмнө тохиролцож гэрээнд гарын үсэг зурсан. Энэ үйлдлээс шалтгаалан 2 компани бүтэн жилийн туршид тооцоо нийлж чадаагүй. Түүнчлэн ЭТТ нь бүтээгдэхүүний өртөг тооцоолж тайлан балансыг эцэслэж чадахгүй байдалд хүрч байсан.

Эндээс харахад ЭТТ нь олборлогч компаниас хараат байдалтай ажилласан байна.

2. 2015 оны Хамтын ажиллагааны гэрээний 7.6 -р заалтад үнийн өөрчлөлтийн зөрүүг жил бүр тооцож уулын ажлын үнэнд тохируулга хийхээр заасан байна. 2016 онд 3.3 сая ам.долларын бууруулах тохируулга, 2017 онд 4.4 сая ам.долларын өсгөх тохируулга хийгдэж үүнийг бүртгэлд тусгасан. 2018 онд ам.долларын ханш дахин чангарч 9.0 сая ам.долларын өсгөх тохируулга хийгдэхээр тооцоолсон байна. “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК нь ЭТТ-ийг хэрвээ энэ тооцооллыг хүлээн зөвшөөрөхгүй бол 3.99 ам.доллар болгосон өртгөө буцааж 4.36 ам.доллар болгоно гэсэн албан бичиг ирүүлсэн байна. 2 тал тохиролцоонд хүрч чадахгүй байгаагаас 2018 оны 12-сарын 31-нээр тасалбар болгосон тооцооны үлдэгдэл батлагдахгүй байна.

Түүнчлэн гэрээний үнийг ам.доллараар хийсэн нь 2009 онд батлагдсан “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн заалтад нийцэхгүй байна.

Гэрээний үнэ ам.доллараар хийгдсэн байхад үнийн өсөлт бууралтын тохируулгын тооцоололд Монгол төгрөгөөрх үнийн өөрчлөлтийн нөлөөг оруулах нь үндэслэлгүй байна.

3. Баруун цанхийн олборлогч компаниуд 1м3 хөрсийг ойролцоогоор НӨАТ шингээгүй үнэ буюу 5,800 төгрөгөөр олборлодог. Харин “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК нь 3.99 ам.доллар буюу 2018 оны хаалтын ханшаар төгрөгт шилжүүлбэл 10,500 төгрөгөөр буюу ойролцоогоор 2 дахин илүү үнээр олборлодог. Баруун цанхийн гэрээний хугацаа дууссан учир шинээр тендер зарлах шаардлага гарч олборлолтыг 6,7,8-р саруудад (тендер шалгаруулалт дахисан) зогсоосон. Зогсолтын хугацаанд Баруун цанхийн олборлогч компаниар нэмэлт гэрээ хийлгэн ажиллуулах боломж байхад өндөр өртөгтэй “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-аар олборлуулсан байна.

2018 оны ТУЗ-ийн баталсан төсвөөр “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК нь 32.5 сая м3 уулын ажил хийх гэрээтэй байсан боловч 41.5 сая м3 уулын ажил хийж 9.0 сая м3-аар төсвийг хэтрүүлсэн байна.

“Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК -ийн илүү хийсэн 9.0 сая м3 уулын ажлыг 2 олборлогчийн үнийн зөрүүгээр тооцоход ойролцоогоор 45.0 тэрбум төгрөгөөр өртөг өссөн байна.

4. Баруун цанхийн олборлогч 2 компани нь “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК -нд мөн туслан гүйцэтгэгч компани болж ажилладаг. Эндээс харахад дотоодын компани зүүн цанхид үндсэн олборлогчоор ажиллах чадвартай нь харагдаж байна.

“Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК нь ЭТТ-тай өндөр үнээр гэрээ хийж, дотоодын компаниар хямд үнээр хийлгэж энэ ажлын дүнгээр цэвэр ашиг олж байна. Харин ЭТТ нь энэ дүнгээр алдагдал хүлээж байна.

3.6.2. Эрсдэл:

ЭТТ нь олборлогч Ти Ти Жэй Ви Си Өү ХХК-аас хэт хараат ажилласнаас шалтгаалан компанийн ашиг буурсан байх эрсдэлтэй байна.

3.6.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Ти Ти Жэй Ви Си Өү ХХК -тай хамтран ажиллахаар шийдвэрлэвэл гэрээний үнийг монгол төгрөг болгож, баруун цанхийн олборлогчтой аль болох ойролцоо байлгах талаар арга хэмжээ авах.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.7. Төсөв ба түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.7.1. Илрүүлэлт:

Компанийн гүйцэтгэх удирдлага жил бүрийн төсвийг ТУЗ-өөр батлуулж батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүй үйл ажиллагаа явуулах ёстой ажилладаг. Гүйцэтгэх удирдлага өгсөн төсвийн хүрээнд хэрхэн ажилласан талаараа гүйцэтгэлд суурилсан төсвийг бэлдэж харьцуулалт хийгээгүй байна.

3.7.2. Эрсдэл:

Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн баталсан төсвийг хэтрүүлсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

3.7.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас ба бүтэн жилээр гаргаж төсвийн хэтрэлт хэмнэлтээ хэлэлцэж дүгнэх.

Төсөв тооцоолох, батлуулах, төсвийг гүйцэтгэлд суурилж залруулах, төсвийн хэтрэлт хэмнэлтийг тооцоолох зэргийг агуулсан төсвийн үйл ажиллагааны журам боловсруулж ажиллах.

Эдгээр тооцоололд суурилсан тайлангуудын бэлтгэгдэж батлагдах огноог журамд оруулах.

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.8. Компанийн засаглалтай холбоотой асуудал

3.8.1. Илрүүлэлт:

Компанийн санхүүгийн тайланг аудитлах явцад дараах асуудлууд ажиглагдлаа.

- 2018 онд ТУЗ болон компанийн гүйцэтгэх захирал солигдсон ба аудит хийх хугацаанд захирлууд компанийн бүтцийг хэд хэдэн удаа өөрчилсөн байна. Сүүлийн байдлаар 2018 оны 8 дугаар сард хийсэн бүтцийн өөрчлөлтийг 2018 оны 12 дугаар сард дахин өөрчилсөн. Үүнээс шалтгаалан ажлын байрны ажил үүргийн хуваарь ойлгомжгүй болж хэн хаана ямар үүрэг хариуцлагатай ажиллаж байгааг компанийн дотоод ажилчид ч мэдэхгүй болсон байна.
- Гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж урамшуулах, хариуцлага тооцох гэрээ болон журам тодорхойгүй байна.

3.8.2. Эрсдэл:

Компанийн засаглалд муугаар нөлөөлөх эрсдэлтэй.

3.8.3. Өгсөн зөвлөмж:

Компанийн бүтцийг олон дахин солих асуудлыг нухацтай авч үзэн нэг төсвийн жилд солихгүй байхыг эрмэлзэх.

Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн үүрэг хариуцлага шагнал урамшууллыг тодорхой болгох.

3.8.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.9. Авто зам, төмөр замд хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

3.9.1. Илрүүлэлт:

Төмөр зам “Гашуун сухайт төмөр зам” ХХК-г байгуулахад 17 хувийн хөрөнгө оруулалт хийж 255,000 ам.доллар дүрмийн санд нь байршуулах байсан боловч 223,865 ам.долларыг төлж, 31,134 ам.долларыг төлөлгүй үлдээсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3-р сарын 20-ны өдрийн 96-р тогтоолын 1-р заалтаар 2013 оны хамтарсан компани байгуулах тухай 299-р тогтоолын 1-р зүйлийг хүчингүй болгож, 2-р зүйлд ЭТТ-г хөрөнгө оруулалтаа татахыг, 4-р зүйлд ЭТТ-ийн эрхийг хөрөнгө оруулахаар сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг холбогдох яамны сайдуудад Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат үүрэг болгосон байна.

Шинээр байгуулсан “Гашуун сухайт төмөр зам” ХХК нь гашуун сухайт хилийн боомтоос 2 улсын хилийг давж хятадын төмөр замтай холбогдох 10 орчим км төмөр замыг барьж ашиглах стратегийн өндөр ач холбогдолтой компани юм. Энэ компанийн 41 хувийг Хятад Улсын төрийн өмчийн хөрөнгө оруулалттай “Шинхуа” компани, үлдсэн 51 хувийг нь Монгол Улсын “Эрдэнэс Таван толгой” ХК, “Энержи ресурс” ХХК, орон нутгийн өмчит “Таван толгой” ХК-иуд тэнцүү 17 хувиар эзэмшиж байна. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн барьж эхэлсэн боловч барилгын ажил зогссон төмөр зам нь Ухаа худгаас – Гашуун сухайт хүрэх ба хилийн наана зогсоно. “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн эзэмшиж байгаа компани нь уг төмөр замыг хил давуулах, 2 улсын хилээр нэвтрэх, хятадын төмөр замтай нийлэх онцгой эрх эдэлж байгаа компани байна.

3.9.2. Эрсдэл:

Хэн нэгэн сонирхсон этгээдэд стратегийн өндөр ач холбогдолтой замыг эзэмших эрхийг өгснөөр дараах асуудал бий болно.

- ЭТТ-ийн нүүрсийг хил давуулахгүй байх эсвэл маш бага квот өгөх
- ЭТТ-ийн нүүрсийг хил давуулах төмөр замын үнийг өндөр болгох

Эдгээрээс шалтгаалан ЭТТ нь нүүрсээ төмөр замаар хил давуулах боломж хаагдах эрсдэлтэй.

3.9.3. Өгсөн зөвлөмж:

Салбарын сайдад хандаж “Гашуун сухайт төмөр зам” ХХК-тай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх.

3.9.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.9.5. Илрүүлэлт:

Авто зам “Гашуун сухайт авто зам” ХХК-д 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж энэ компанийн 40 хувийг эзэмшиж байна. Тус компани нь Таван толгойгоос Гашуун сухайт хүрэх авто замын арчилгаа, удирдлага зохион байгуулалт хийдэг. Хатуу хучилттай авто зам нь “Эрдэнэс Монгол” ХХК-д бүртгэлтэй ба орлогыг нь “Гашуун сухайт авто зам” ХХК “Эрдэнэс Монгол” ХХК-д төвлөрүүлж өгдөг. “Эрдэнэс Монгол” ХХК нь “Гашуун сухайт авто зам” ХХК-д жилийн ажлын төлөвлөгөөнд нь тохируулж төсөв өгч санхүүжүүлдэг.

ЭТТ-ийн зүгээс оруулсан хөрөнгө оруулалтандаа анхаарал тавьж хөрөнгө оруулалтын өгөөж болон түүний бүртгэлийн талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна. Тус компанид 40 хувь эзэмшиж байгаа боловч санхүүгийн тайланд өмчийн аргаар нэгтгэл хийгээгүй байна.

3.9.6. Эрсдэл:

Хөрөнгө оруулалтын өгөөжийг сайжруулах арга хэмжээ аваагүй ба хяналт тавьж ажиллаагүй байна.

3.9.7. Өгсөн зөвлөмж:

Гашуун сухайт авто замд хийсэн хөрөнгө оруулалтандаа анхаарал хандуулж илүү ашигтай ажиллуулах талаар арга хэмжээ авах, ногдол ашиг хуваарилуулах эсэх талаар харилцан тохиролцож ажиллах.

3.9.8. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.10. Нүүрсний үлдэгдэлд хяналтын тооллого хийсэнтэй холбоотой асуудал

3.10.1. Илрүүлэлт:

Нүүрсийг талбайгаас орлогод авахдаа маркшейдерийн тооцоолсон нүүрсний биетийн эзэлхүүнийг 1.1 гэсэн коэффициентээр үржүүлж тоннд шилжүүлдэг.

2018 оны 12 дугаар сарын 31-нээр ЭТТ маркшейдерүүд хэмжилт хийдэг ба энэ хэмжилтийг бататгах зорилгоор хөндлөнгийн маркшейдерийн компаниар хэмжилт хийлгэсэн. Хяналтын компани ЭТТ-ийн маркшейдерийн хэмжилттэй өөрийн хэмжилтийг харьцуулж үзээд 0.31%-ийн зөрүү гарсан нь техникийн шаардлага хангаж байна гэсэн дүгнэлт өгсөн.

Энэ тайлангаас ЭТТ-ийн буюу үндсэн маркшейдерүүд хэмжилтээ үндэслэлтэй гэж үзсэн боловч агуулахын бүртгэлийн үлдэгдлээ залруулаагүй.

Цагаан хад дахь агуулахад бодит хэмжээгээрээ 8,818 тонн нүүрс анх буусан. Одоогийн хэмжилтээр 5,794 тонн болж тухайн нүүрсний хувьд 39 орчим хувийн зөрүү үүссэн байна.

3.10.2. Эрсдэл:

Маркшейдерийн хэмжилтээр бүртгэлдээ залруулга хийхгүй байснаас нүүрсний үлдэгдэл буруу илэрхийлэгдэх эрсдэл үүснэ.

3.10.3. Өгсөн зөвлөмж:

Тайлант хугацааны эцэст маркшейдерийн хэмжилтээр НББ-д залруулга оруулж байх талаар тусгасан журам гарган түүнийгээ НББ-ийн бодлогод тусгаж мөрдөн ажиллах шаардлагатай. Ингэснээр овоолго хаагдах бүрд үүсч байгаа бүртгэл болон бодит байдлын зөрүү багасах боломжтой.

Цагаан хад дахь агуулахад байгаа нүүрс бодит үлдэгдлээс зөрж байгаа дүнгийн шалтгааныг тодруулж бүртгэлд залруулга хийх.

3.10.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.11. Лицензээрх биет бус хөрөнгө болон түүний элэгдүүлэлттэй холбоотой асуудал

3.11.1. Илрүүлэлт:

Өмнөх жилийн аудитаар ЭТТ-ийн лицензээрх биет бус хөрөнгийг 11,196,000.0 сая төгрөгөөр үнэлсэн тооцооллыг нотлох баримтгүй гэж үзээд хязгаарлалтын үндэслэл болгосон. Энэ жил энэхүү тооцооллын үндэслэлийг гаргаж өгөхийг шаардсан боловч ЭТТ нь албан ёсоор хариу өгөөгүй.

ЭТТ-ийн бүртгэлд 11,196,000.0 сая төгрөгийн биет бус хөрөнгийг нийт 7 лицензэд хувааж одоогийн ашиглаж байгаа зүүн ба баруун цанхийн лицензэд холбоотой хэсгийг элэгдүүлж 17,400.0 сая төгрөгөөр өртөгт шингээсэн байна.

3.11.2. Эрсдэл:

Биет бус хөрөнгийн үнэлгээ нотлох баримтгүй үнэн зөв эсэхийг нь удирдлага нотолж чадаагүй байхад энэ үнэлгээг элэгдүүлэх нь асуудлыг хүндрүүлж байна.

3.11.3. Өгсөн зөвлөмж:

ЭТТ 2017 оны эцэст лицензийг үнэлж бүртгэсэн ба 2018 онд анхны элэгдүүлэх бичилтээ хийсэн. Тухайн хөрөнгийн үнэлгээ үнэн байсан эсэх нь 2019 онд хийх IPO-ийн ажлын хүрээнд хийгдэх бизнес үнэлгээ, олон улсын аудит, ТЭЗҮ зэргээс тооцоологдон

гарч ирэхээс гадна IPO хийгдэж хувьцаа зарагдах мөчид хамгийн эцсийн баталгаатай үнэлгээ нь гарч ирэх нь ойлгомжтой байгаа. Иймд IPO хийгдэж үнэлгээ бодит болсны дараа биет бус хөрөнгө болон түүний элэгдүүлэлтийн бодлогыг дахин хянаж бодит тооцооллыг гаргаж мөрдөх.

3.11.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.12. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал

3.12.1. Илрүүлэлт:

НӨАТ

Түр шилжсэн ажилчдын цалин болон бусад үйлчилгээнээсээ орлого хүлээн зөвшөөрч НӨАТ төлдөг. Уг орлогын нийт борлуулалтын дүнд эзлэх хувиар тооцож худалдан авалтын НӨАТ-ын буцаалт бүртгэдэг.

ААНОАТ

Авлага, өглөгийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэлийг санхүүгийн програмаар сар бүрийн эцэст хийлгэж бодит бус олз гарзыг бүртгэдэг боловч бодит олз гарзыг тооцоолж програмд залруулга хийдэггүй.

3.12.2. Эрсдэл:

Тайлант үеийн татварын зардлыг буруу тооцоолох эрсдэлтэй байна.

3.12.3. Өгсөн зөвлөмж:

- НӨАТ-ын буцаалт ашиглахдаа түр шилжсэн ажилчдын цалинтай холбоотой буцаалтыг авч болох эсэхийг сайтар судалж компанийг эрсдэлд оруулахгүй байх хувилбарыг авч хэрэгжүүлэх
- Авлага өглөгийн хувьд ханшийн бодит олз гарзыг тооцоолж бүртгэлд залруулга хийх журам гаргаж мөрдөх.

3.12.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.13. Мөнгөн гүйлгээний тайлантай холбоотой асуудал

3.13.1. Илрүүлэлт:

Санхүүгийн програмын сул талаас шалтгаалан програм мөнгөн гүйлгээний тайланг буруу бэлтгэж байна.

3.13.2. Эрсдэл:

Мөнгөн гүйлгээний тайлан алдаатай гарах эрсдэлтэй.

3.13.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмд сайжруулалт хийх боломж байгаа эсэхийг програм нийлүүлсэн компаниар судлуулж засварлуулах арга хэмжээ авах, хэрвээ боломжгүй бол мөнгөн гүйлгээний тайланг залруулж бэлтгэх.

3.13.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	88,401,226,493.82	605,258,483,115.02
1.1.2	Дансны авлага	24,184,390,200.38	49,626,543,289.34
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	10,213,420,382.41	65,686,144.78
1.1.4	Бусад авлага	418,067,128.41	402,557,437.93
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	6,591,680,454.00	15,325,989,041.03
1.1.6	Бараа материал	178,218,101,026.34	104,110,861,900.76
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	6,607,844,825.21	8,725,262,029.81
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	392,534,246.50
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	314,634,730,510.57	783,907,917,205.17
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	20,238,312,632.12	31,646,323,042.66
1.2.2	Биет бус хөрөнгө	11,194,157,138,474.20	11,184,756,406,143.10
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	583,351,666.14	462,009,157.49
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	1,224,662,866.73	10,649,413,859.75
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	10,909,550,573.93	62,632,515.73
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	304,790,483,979.50	313,157,059,730.01
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,531,903,500,192.60	11,540,733,844,448.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,846,538,230,703.20	12,324,641,761,653.90
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	80,205,950,213.53	94,022,780,176.11
2.1.1.2	Цалингийн өглөг	955,813,925.63	6,586,867,856.68
2.1.1.3	Татварын өр	14,428,701,269.15	67,551,892,688.09

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.4	НДШ–ийн өглөг	34,011,766.24	83,279,468.64
2.1.1.5	Богино хугацаат зээл	121,356,500,000.00	-
2.1.1.6	Хүүний өглөг	94,104,196,555.41	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	149,467,471,535.31	106,941,522,718.73
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	10,032,029,336.60
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	460,552,645,265.27	285,218,372,244.84
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	121,356,500,000.00	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	31,808,479,597.23	31,808,479,597.23
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	3,787,986,607.85
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	153,164,979,597.23	35,596,466,205.08
2.2	Өр төлбөрийн нийт дүн	613,717,624,862.50	320,814,838,449.92
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат	11,196,000,000,000.00	11,196,000,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	36,820,605,840.75	807,826,923,203.94
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	11,232,820,605,840.70	12,003,826,923,203.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	11,846,538,230,703.20	12,324,641,761,653.90

4.2. Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,182,364,018,363.60	1,986,874,104,288.29
2	Борлуулалтын өртөг	381,175,581,819.66	680,578,288,303.93
3	Нийт ашиг(алдагдал)	801,188,436,543.94	1,306,295,815,984.37
4	Түрээсийн орлого	-	77,885,426.57
5	Хүүгийн орлого	1,946,557,445.36	4,038,235,063.30
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	9,692,101,883.74	21,132,405,048.80
9	Борлуулалт, маркетингийн зардал	159,872,978,998.43	278,690,232,113.50
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,832,332,780.13	16,640,425,130.82
11	Санхүүгийн зардал	39,521,255,700.26	4,587,765,729.62
12	Бусад зардал	16,870,872,565.65	28,723,295,782.68
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(31,088,317,451.06)	28,877,715,918.49
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(30,113,794.14)	(65,894,929.61)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	554,611,224,583.37	1,031,714,443,755.30
19	Орлогын татварын зардал	93,541,814,887.27	224,152,246,749.85
20	Татварын дараах ашиг (алдагдал)	461,069,409,696.10	807,562,197,005.46
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	461,069,409,696.10	807,562,197,005.46
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00						(416,563,125,470.31)	(416,263,125,470.31)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(7,685,678,385.04)	(7,685,678,385.04)
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							461,069,409,696.10	461,069,409,696.10
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт	11,195,700,000,000.00							11,195,700,000,000.00
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	-	-	-	-	36,820,605,840.75	11,232,820,605,840.70
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(36,555,879,642.27)	(36,555,879,642.27)
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							807,562,197,005.46	807,562,197,005.46
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,196,000,000,000.00	-	-	-	-	-	807,826,923,203.94	12,003,826,923,203.90

4.4. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,000,277,441,608.32	1,748,187,478,071.33
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	925,983,243,668.65	1,705,463,601,128.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	17,364,604.00	47,220,621.06
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	74,276,833,335.67	42,676,656,322.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(707,264,862,355.49)	(983,289,742,759.21)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(17,114,201,908.76)	(22,424,325,556.73)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(4,260,231,565.00)	(6,686,011,766.24)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(279,251,709,994.82)	(400,823,015,474.00)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(32,851,494.38)	(37,366,915.05)
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,257,277,345.88)	(1,608,547,982.91)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	(34,923,052,744.75)	(98,370,442,285.03)
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(213,856,221,890.59)	(391,975,591,890.17)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(88,982,417.26)	(197,012,531.38)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(156,480,332,994.05)	(61,167,428,357.70)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	293,012,579,252.83	764,897,735,312.12
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	4,027,911,277.56
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	4,027,911,277.56
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8			

“Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(1,830,614,872.50)	(41,992,091,079.55)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(815,945,472.50)	(6,175,308,040.85)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,014,669,400.00)	(1,916,783,038.70)
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	(33,900,000,000.00)
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,830,614,872.50)	(37,964,179,801.99)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(245,621,000,000.00)	(239,664,870,000.00)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(245,621,000,000.00)	(239,664,870,000.00)
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(245,621,000,000.00)	(239,664,870,000.00)
4	Валютын ханшийн зөрүү	1,313,777,313.59	29,588,571,111.07
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	46,874,741,693.92	516,857,256,621.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,526,484,799.90	88,401,226,493.82
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,401,226,493.82	605,258,483,115.02

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/60/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрдэнэс Таван толгой ХК		сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Зүүн цанхийн уурхайн олборлогч “Ти Ти Жэй Ви Си Өү” ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хоорондын тооцооны үлдэгдлээ нийлж чадаагүй.		Дүгнэлт хязгаарлах	Гүйцэтгэх захирал Хууль зүй хариуцсан газрын захирал	Т.Билгээ Э.Онон
2	Нүүрсний өртөгт шингэсэн Хөрс хуулалтын зардал болон элэгдлийн нийт дүн ТЭЗҮ-д заасан тухайн үе шатны коэффициентээс илүү гарсан байна.		Албан шаардлага өгөх	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	М.Мягмар-Эрдэнэ
3	Нүүрс хучилтын орлогын тооцоог хийхтэй холбоотойгоор орон нутаг хариуцсан нягтлан бодогч үндсэн үйл ажиллагааны бүртгэлийн ачааллын зэрэгцээ үндсэн бус үйл ажиллагаанд илүү их анхаарал хандуулж цаг хугацаа зарцуулж байна.		Зөвлөмж өгөх	Бизнесийн удирдлагын газар хариуцсан дэд захирал Маркетинг, Борлуулалтын хэлтсийн дарга	Б.Батсайхан С.Амгалан
4	Мөнгөн хөрөнгийн менежмент хийгээгүй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Д.Ариунболд

5	Компани үндсэн үйл ажиллагаанаас НӨАТ төлдөггүй, буцаан авалт хийдэггүй боловч НББ-д тусгахдаа худалдан авалтаас НӨАТ-ыг салгаж бүртгээд нэг бүрчлэн буцааж бичдэг. Энэ бүртгэл нь журналын бичилтийн тоог эрс ихэсгэж, санхүүгийн тайланд алдаа гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.		Зөвлөмж өгөх	Татварын асуудал хариуцсан менежер	Р.Даваа
6	Нөхөн сэргээлтийн хөрөнгийг хэрхэн бүртгэх, элэгдүүлэх талаар тогтмол хэрэгжүүлдэг бодлого журамгүй байна.		Зөвлөмж өгөх	Уул уурхайн хэлтсийн дарга Нягтлан бодогч	Д.Цагаан-Өвгөн М.Агаамаа
7	“Майнс ап” ХХК-аас Тендерийн техникийн шаардлага хангахгүй 2 ширхэг утгуурт ачигч худалдан авсан байна.	2,998.6	Зөвлөмж өгөх	Захиргаа, удирдлага хариуцсан газрын захирал Уул уурхайн хэлтсийн дарга	Ө.Сумъяабаатар Ц.Анхбаяр
8	Ти Ти Жэй Ви Си Өү ХХК нь Зүүн цанхийн уурхайн ганц гэрээт олборлогч тул хэт хараат байдлаар ажиллах асуудал үүссэн. Мөн олборлолтын ажлын гэрээг ам.доллараар хийсэн, жилийн дундуур ажлын төлөвлөгөөг нэмж өгсөн байна. Уг компани дотоодын олборлогч компаниудаар хямд үнээр ажил хийлгэж цэвэр ашиг олж байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Хууль зүй хариуцсан газрын захирал	Т.Билгээ Э.Онон
9	Гүйцэтгэх удирдлага батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Гэвч гүйцэтгэлд суурилсан төсөв бэлтгэж харьцуулалт хийдэггүй.		Зөвлөмж өгөх	Эдийн засаг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	М.Гэрэл

10	Нэг санхүүгийн жилд компанийн удирдлага болон ТУЗ-ийн гишүүд солигдож энэ нь мөн компанийн бүтцийг олон дахин өөрчлөхөд хүргэсэн. Гүйцэтгэх удирдлагын багийн шагнал ба хариуцлага тодорхой бус байсан.		Зөвлөмж өгөх	ТУЗ-ийн дарга	М.Баяраа
11	“Гашуун сухайт төмөр зам” ХХК-д хөрөнгө оруулалт хийсэн боловч Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3-р сарын 20-ны өдрийн 96-р тогтоолын 1-р заалтаар 2013 оны хамтарсан компани байгуулах тухай 299-р тогтоолын 1-р зүйлийг хүчингүй болгож, 2-р зүйлд ЭТТ-г хөрөнгө оруулалтаа татахыг, 4-р зүйлд ЭТТ-ийн эрхийг хөрөнгө оруулахаар сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийхийг үүрэг болгосон. “Гашуун сухайт авто зам” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтандаа анхаарал тавьж хөрөнгө оруулалтын өгөөж болон түүний бүртгэлийн талаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.		Зөвлөмж өгөх	Худалдан авалт, дэд бүтэц эрхэлсэн дэд захирал Тээвэр, ложистик хариуцсан менежер	Ц.Хангай Д.Дамдиндорж
12	2018 оны 12 дугаар сарын 31-нээр агуулахад байгаа нүүрсний үлдэгдлийг компанийн маркшейдерүүд хэмжиж хөндлөнгийн маркшейдерийн компаниар хянуулсан. Бүртгэл дэхь нүүрсний үлдэгдлийг маркшейдерүүдийн хэмжилтээрх нүүрсний үлдэгдэлтэй тохируулж залруулга хийгээгүй.		Зөвлөмж өгөх	Ахлах маркшейдер Ахлах нябо	Б.Мөнхзаяа Д.Энхжаргал

13	Лицензээрх биет бус хөрөнгийн анхны тооцооллыг нотлох баримт олж чадаагүй, иймд түүнд суурилж тооцоологдсон элэгдлийг мөн үнэн гэж үзэх боломжгүй байсан.		Зөвлөмж өгөх	"Эрдэнэс Монгол" ХХК-ийн санхүү хариуцсан дэд захирал	Ганболд
14	Түр шилжсэн ажилчдын цалин болон бусад компаниудад үзүүлсэн жижиг үйлчилгээнээс орлого бүртгэж НӨАТ төлдөг ба уг орлогын нийт орлогод эзлэх хувиар тооцож НӨАТ буцаалт бүртгэдэг. Авллага, өглөгийн үлдэгдэлд ханшийн тэгшитгэлийг програм сар бүрийн эцэст хийж бодит бус олз гарзыг бүртгэдэг боловч бодит олз гарзыг тооцоолж програмд залруулга хийдэггүй.		Зөвлөмж өгөх	Татварын асуудал хариуцсан менежер	Р.Даваа
15	Санхүүгийн програмын сул талаас шалтгаалан програм мөнгөн гүйлгээний тайланг буруу бэлтгэж байна.		Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Д.Алтанцэцэг
Дүн		2,998.6			